

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 08 дугаар сарын 12

Дугаар 105

Улаанбаатар хот

Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ухуулах хуудас  
болон сурталчилгааны зурагт самбарыг  
байрлуулах байршлыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.3, 41.4, 41.9 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хорьдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас болон зурагт самбарыг хавсралтад заасан байршлаас бусад нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газарт үнэ төлбөргүйгээр байрлуулахыг зөвшөөрсүгэй.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргад үүрэг болгосугай.

ДАРГА

А.БАЯР

Баянзүрх дүүргийн иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ..... дугаар  
сарын .....-ны өдрийн хорьдугаар хуралдааны  
..... тогтоолын хавсралт

**Сонгуулийн сурталчилгааны зурагт болон ухуулах  
хуудсыг байрлуулахыг хориглосон байршил**

| Д/д | Сонгуулийн сурталчилгааны зурагт болон ухуулах хуудсыг байрлуулахгүй гудамж, зам, талбайн нэр | Хамаарах хороод                    |
|-----|---|------------------------------------|
| 1   | Дарь-Эхийн гудамж   | 2, 21, 27, 29                      |
| 2   | Токиогийн гудамж  | 1, 3                               |
| 3   | Их тойруугийн гудамж  | 1, 2, 3, 7, 29                     |
| 4   | Намъяанжугийн гудамж  | 14, 15, 18, 25, 42                 |
| 5   | Б.Доржийн гудамж  | 2, 4, 5, 7, 19, 22, 30, 31, 32, 41 |
| 6   | Энхтайвны өргөн чөлөө   | 3, 4, 5, 6, 7, 13, 14, 15, 22, 41  |
| 7   | Алтан-Өлгийн гудамж   | 19, 32                             |
| 8   | Дандарбаатарын гудамж   | 16, 22, 40                         |
| 9   | Да хүрээ гудамж   | 16, 17, 19, 24, 38, 40             |
| 10  | Шархадны гудамж   | 9, 17                              |
| 11  | Улаанхуарангийн гудамж  | 16, 38, 39                         |
| 12  | Цагдаагийн академийн өргөн чөлөө  | 8, 10, 12, 37, 38, 39              |
| 13  | Нарны зам   | 13, 25, 37, 42, 43                 |
| 14  | Залуучуудын гудамж  | 1, 3                               |
| 15  | Их хүрээ гудамж   | 26, 36                             |
| 16  | Улиастайн авто замаас Гачууртын авто зам дуустал  | 20, 23, 28, 33                     |
| 17  | Жанжны гудамжны авто зам  | 12, 37                             |
| 18  | Монелийн гудамж   | 31, 32                             |
| 19  | Хилчний гудамж  | 4                                  |
| 20  | Жуковын талбай  | 4, 41                              |
| 21  | Сансарын үйлчилгээний төв талбай  | 3                                  |
| 22  | Эскадрилын хөшөө (Нисгэгчийн талбай)  | 8, 13, 16, 22, 39                  |
| 23  | Бөхийн өргөөний талбай  | 6, 15                              |
| 24  | Гадна тойруугийн зам  | 21, 27, 31, 32                     |
| 25  | Их Монгол Улсын гудамж  | 26, 36                             |
| 26  | Шархадны гудамжнаас Улиастайн гүүр хүртэлх авто зам   | 9, 10, 17, 23, 34, 35              |
| 27  | Дүнжингаравын гудамж  | 11                                 |